



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2020 оны 06 сарын 17 өдөр

Дугаар 418

Арвайхээр

Ажлын хэсэг байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4 дэх заалт, Татварын ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2020 оны А-109/А-105 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Татварын ерөнхий /шинэчилсэн найруулга/ хууль, уг хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 6 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангах, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад байгаа баримт бичгийг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Захиргаа, хуулийн тасгийн дарга

Нарийн бичгийн дарга:

Жижиг татвар төлөгчтэй харилцах тасгийн дарга

Гишүүд:

Бичил татвар төлөгчтэй харилцах тасгийн дарга

Жижиг татвар төлөгчтэй харилцах тасгийн татварын улсын байцаагч

Бичил татвар төлөгчтэй харилцах тасгийн татварын улсын байцаагч

2. Дээрх хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч Захиргаа, хуулийн тасгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /А.Ганчимэг/-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙН ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧИЙН АЖЛЫН ХЭСЭГ  
А.ГАНЧИМЭГ



106181035